



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/558

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 32 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Хавдаргүй Монгол Эмэгтэй” нийгмийн зорилтот төслийн хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар нь “Монголын Эмэгтэйчүүдийн холбоо” төрийн бус байгууллагатай хамтран сумдад хэрэгжүүлэх явуулын тусламж үйлчилгээ, үзлэг, оношлогоо, соёлын арга хэмжээнд зарцуулагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 26,620,000 (хорин зургаан сая зургаан зуун хорин мянга) төгрөгийг орон нутгийн төсвийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Батзориг)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2022 оны
0.9 дүгээр сарын 0.1.-ны өдрийн А/558
дугаар захирамжийн хавсралт

"ХАВДАРГҮЙ МОНГОЛ ЭМЭГТЭЙ" зорилтот төслийн төсөв

№	Зардлын үзүүлэлт	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт зардал
1	Үзлэгийн багаж хэрэгсэл /ком/	2160	5000	10800000
2	Жолоочийн хөлс	150000	22 өдөр 1 хүн	3300000
3	Шатахууны зардал /нийт туулах зам 2221 км/	2800	460л * 2 машин	2520000
4	Сургагч багш нарын сургалтын төлбөр	100000	5 багш 18 сум, 2 тосгон	10000000
5	Төслийн багийн байрны зардал	Сум хариуцна.		
6	Төслийн багийн хоол ундны зардал			
7	Үсчин бэлтгэх сургалтын зардал /ХХҮГ хариуцна/	160000	20	3600000
8	Гоо сайханч, маникюрчин бэлтгэх сургалтын зардал /ХХҮГ хариуцна/	160000	20	3600000
9	Шилэн урлалын сургалтын зардал /МЭХ хариуцна/	150000	20	3000000
10	Машин тоноглох зардал /МЭХ хариуцна/	75000000	1	75000000
11	Лектор, урлагийн номерын зардал /МЭХ хариуцна/	15000000	2	30000000
12	Улаанбаатараас ирэх багийн шатахууны зардал /МЭХ хариуцна/	3450000	2	6900000
Нийт зардал				148720000
Орон нутгийн төсвөөс гаргах зардал				26620000

...oOo....